



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Говьсүмбэр аймгийн 18 дугаар зөрлөгөөс Баянтал сум руу салаалсан 1.5 км салаа төмөр замыг хөндлөнгийн хараат бус хөрөнгийн үнэлгээчний тогтоосон нийт 616,900,863.36 (зургаан зуун арван зургаан сая есөн зуун мянга найман зуун жаран гурван төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгөөр тооцон төрийн өмчид хүлээн авч “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгө (эзэмшигчийн өмч)-д бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн захирал О.Батнасанд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Салаа төмөр замын зурвас газрыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн нэр дээр баталгаажуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001050

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 01 дүгээр сарын 20 ны өдрийн
10 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжээ (метр)	Үнэ (төгрөгөөр)
1	Салаа төмөр зам (Говь-сүмбэр аймгийн 18 дугаар зөрлөгөөс Баян тал сумруу салсан)	1989	1500	616,900,863.36
				616,900,863.36
	Нийт дүн			(зургаан зуун арван зургаан сая есөн зуун мянга найман зуун жаран гурван төгрөг гучин зургаан мөнгө)